



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/96

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а” дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Бүрд, Баян-Өндөр, Есөн-Зүйл, Өлзийт сумдын нутгаар 2018-2019 оны мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндрэх нөхцөл байдал үүссэн тул Булган аймгийн Рашаант суманд дээрх сумдын 66 өрхийн 39.4 мянган мал оторлож байгаатай холбогдуулан 1.350.000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээний зардлын 1.350.000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100224